

Арван зургаадугаар зүйл

1. Консул нь тойрогтоо нас барсан өөрийн улсын иргэдийн өв залгамжлагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зайлшгүй хамгаалахад чиглэгдсэн бух арга хэмжээг авахуулах талаар ажиллана.

2. Консулын тойрог дахь орон нутгийн байгууллагууд нь консулыг томилсон улсын иргэн нас барсан тухай ба мөн тууний өв хөрөнгийг зохицуулах арга хэмжээ авсныгаа консулд мэдэгдэнэ.

Арван долдугаар зүйл

1. Өв хөрөнгийг битуумжлэх, хадгалах, тодруулах явдал нь суугаа улсын орон нутгийн байгууллагын эрх хэмжээний дотор байна. Эдгээр байгууллага консулын өөрийн хусэлтээр өв хөрөнгийг хамгаалах зайлшгүй арга хэмжээг авна. Орон нутгийн байгууллагаас өв хөрөнгийг тодруулах хамгаалах арга хэмжээ авахад консул байлцаж өв хөрөнгийг данслах, битуумжлэхэд оролцож болно. Хэрэв нас барсан иргэний баримт бичиг зэрэг хөдлөх хөрөнгийг орон нутгийн байгууллага хадгалж байсан бол уул хөрөнгийг шилжуулэн өхийг туунээс консул шаардах эрхтэй.

2. Өв залгамжлагчид өх өв хөрөнгийг шилжуулэхийн өмнө буюу гадаадад тээвэрлэн гаргахын өмнө уг өв хөрөнгийн хэмжээгээр тогтоогдсон хураамжийг төлсөн байх ёстой ба суугаа оронд байгаа өөр өв залгамжлагч буюу бусад хумуусийн гаргасан гомдлыг таслан барагдуулсан байвал зохино.

3. Ул хөдлөх хөрөнгийн талаар уул хөрөнгийг байгаа улсын хууль зуйд зааснаар шийдвэрлэнэ.

Арван наймдугаар зүйл

1. Гэрлэгсэд нь хоёулаа консулыг томилсон улсын иргэн бөгөөд өөрийн улсын хууль зуйд нийцнэ гэж консул узвэл уул гэр булийг бүртгэх эрхтэй болно*. Консул нь гэр булийг бүртгэсэн тухайгаа суугаа орны зохих байгууллагат мэдэгдэнэ.

2. Гэрлэгсдийн нэг нь томилсон улсын иргэн, нөгөө нь суугаа орны харьяат бол гэр булийг батлуулах гэсэн өрөгдлийг суугаа орны зохих байгууллагат консулыг томилсон орны